

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОО-2024/005/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4207, Цахим хаяг: [oyunkherlenb@audit.gov.mn](mailto:oyunkherlenb@audit.gov.mn)

Аудитор: Б.Одхүү

Утас: 7058-4207, Цахим хаяг: [odkhuub@audit.gov.mn](mailto:odkhuub@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.5.1 Завсрын аудитын талаар.....	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	14
5.1 Төлбөрийн акт .....	14
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Г ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ө ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг Хэрлэн сум Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр Утас/Факс: 7058-4203

2025.03.14 № 395

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

“Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50МВт-ын шинэ станцаар өргөтгөх” төсөл хэрэгжиж, 2024 оны 08 дугаар сараас эхлэн ашиглалтад орсон байна.

Дээрх өргөтгөлийн ажилтай холбоотой Монгол Улсын хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн 191,814.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудал**

Эрчим хүчний салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан ажилтан болон ахмад ажилчдад сар бүр 15,000.0 төгрөгийг байгууллагын захиргаа, үйлдвэрчний эвлэл хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу олгож байна.

011022175

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд Засгийн газрын 2023 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 3.1.7 дахь “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх” гэсэн шаардлагыг хангаагүй хүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 08 дугаар тогтоолоор томилсон байна.

**Удирдлага болон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б БОЛОРТУУЛ

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант үе	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	247,398,223.51	505,610,115.82
1.1.2	Дансны авлага	1,543,372,328.37	1,583,178,451.33
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,391,527,240.70	1,297,983,130.95
1.1.4	Бусад авлага	108,832,319.35	124,417,659.14
1.1.6	Бараа материал	3,199,738,852.87	5,544,933,928.53
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	31,913,623.47	22,289,502.50
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	216,819,000.00	126,867,500.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,739,601,588.27</b>	<b>9,205,280,288.27</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	227,366,318,025.82	348,518,986,848.55
1.2.2	Биет бус хөрөнгө	19,080,918,248.69	19,018,997,208.95
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>246,447,236,274.51</b>	<b>367,537,984,057.50</b>
<b>1.30</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>253,186,837,862.78</b>	<b>376,743,264,345.77</b>
2.1.1.1	Дансны өглөг	9,311,695,416.94	21,050,004,977.67
2.1.1.2	Цалингийн өглөг	16,584,020.13	-
2.1.1.3	Татварын өр	2,196,840,146.18	4,367,208,055.70
2.1.1.4	НДШ-ийн өглөг	107,180,635.19	1,286,409.04
2.1.1.6	Хүүний өглөг	1,278,168,317.53	2,632,126,047.20
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	603,391,874.19	113,412,128.55
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>13,513,860,410.16</b>	<b>28,164,037,618.16</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	114,379,788,915.15	199,417,924,298.59
2.1.2.5	Хойшлогдсон орлого	42,308,425,697.44	68,698,699,283.66
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>156,688,214,612.59</b>	<b>268,116,623,582.25</b>
<b>2.20</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>170,202,075,022.75</b>	<b>296,280,661,200.41</b>
2.3.1	᠙+/- төрийн	51,590,219,512.43	51,590,219,512.43
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,111,700,363.84	11,106,873,783.86
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,325,030,500.68	18,427,130,553.03
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,957,812,463.08	-661,620,703.96
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>82,984,762,840.03</b>	<b>80,462,603,145.36</b>
<b>2.40</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>253,186,837,862.78</b>	<b>376,743,264,345.77</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	66,502,657,078.86	75,118,772,206.86
2	Борлуулалтын өртөг	44,155,853,157.11	58,695,307,902.21
<b>3</b>	<b>Нийт ашиг/алдагдал/</b>	<b>22,346,803,921.75</b>	<b>16,423,464,304.65</b>
4	Түрээсийн орлого	32,057,090.84	35,063,605.10
5	Хүүний орлого	11,081,897.93	45,404,846.77
8	Бусад орлого	1,688,188,824.65	8,076,051,337.37
9	Борлуулалт, маркетингийн зардал	12,240,707,060.38	14,673,484,590.13
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,954,848,650.34	4,075,364,814.15
11	Санхүүгийн зардал	67,771,125.12	6,136,127,774.22
12	Бусад зардал	3,814,652,677.63	4,129,667,060.63
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	390,902,536.38	2,678,668,830.90
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>5,391,054,758.08</b>	<b>-1,755,991,314.34</b>
19	Орлогын татварын зардал	511,913,563.20	136,397,253.44
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>4,879,141,194.88</b>	<b>-1,892,388,567.78</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>4,879,141,194.88</b>	<b>-1,892,388,567.78</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>4,879,141,194.88</b>	<b>-1,892,388,567.78</b>

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	<b>73,380,881,451.97</b>	<b>88,906,916,695.83</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	71,704,405,091.13	80,282,387,914.42
1.1.3	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	81,517,716.00	1,430,512.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		5,791,100,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,594,958,644.84	2,831,998,269.41
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>65,335,147,533.05</b>	<b>75,171,491,160.50</b>
1.2.1	Ажилчдад төлсөн	18,480,331,251.27	24,161,888,820.94
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,529,088,533.24	7,265,481,290.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	16,067,957,842.90	7,905,720,760.77
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	36,745,415.73	-
1.2.5	Тулш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,009,336,116.36	17,591,017,031.78
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	2,958,171,936.20	8,204,473,549.14
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,705,515,254.11	5,080,193,892.36
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	189,931,832.40	128,525,966.66
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,358,069,350.84	4,834,189,848.85
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>8,045,733,918.92</b>	<b>13,735,425,535.33</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.	Мөнгөн орлогын дүн (+)	<b>25,444,762.32</b>	<b>51,374,348.40</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	14,375,000.00	5,968,500.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	11,069,762.32	45,405,848.40
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>81,126,732,734.93</b>	<b>95,307,451,449.17</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	4,930,929,049.51	4,388,001,295.11
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	737,571,946.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	75,458,231,739.42	90,919,450,154.06
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-81,101,287,972.61</b>	<b>-95,256,077,100.77</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>74,373,557,534.42</b>	<b>90,919,450,154.06</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	74,373,557,534.42	90,919,450,154.06
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,559,627,795.96</b>	<b>9,140,586,696.31</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,534,923,679.80	8,299,301,150.68
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	24,696,683.91	109,414,366.39
3.2.4	Төлсөн ногдол ашиг	7,432.25	731,871,179.24
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний</b>	<b>72,813,929,738.46</b>	<b>81,778,863,457.75</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-241,624,315.23</b>	<b>258,211,892.31</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>489,022,538.74</b>	<b>247,398,223.51</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>247,398,223.51</b>	<b>505,610,115.82</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>1</b>	<b>2022 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл</b>	51,370,219,512.43	11,132,551,322.91	18,545,030,500.68	-2,942,172,258.62	78,105,629,077.40
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				4,879,141,194.88	-3,981,774,159.49
6	Өмчид гарсан өөрчлөлт	220,000,000.00		-220,000,000.00		0.00
7	Зарласан ногдол ашиг				-7,432.25	-7,432.25
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-20,850,959.07		20,850,959.07	0.00
<b>9</b>	<b>2023 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл</b>	51,590,219,512.43	11,111,700,363.84	18,325,030,500.68	1,957,812,463.08	82,984,762,840.03
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-1,892,388,567.78	-1,892,388,567.78
13	Бусад дэлгэрэнгүй орлого			102,100,052.35		102,100,052.35
15	Зарласан ногдол ашиг				-731,871,179.24	-731,871,179.24
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-4,826,579.98		4,826,579.98	0.00
<b>17</b>	<b>2024 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл</b>	51,590,219,512.43	11,106,873,783.86	18,427,130,553.03	-661,620,703.96	80,462,603,145.36

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

д/д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 он			Төлөвлөгөөтэй	
				анх.төл	тод.төл	гүйц	тод.төл-с	хувиар
1	ЦЭХ боловсруулалт		сая. кВтц	337.2	288.2	296.07	7.9	102.7%
2	ДХЦЭХ	хувь	хувь	13.2%	13.8%	13.9%	0.05%	99.6%
		биет	сая. кВтц	44.52	39.87	41.13	1.3	96.9%
<b>Нийт түгээх ЦЭХ</b>			<b>сая. кВтц</b>	<b>322.1</b>	<b>324.2</b>	<b>330.8</b>	<b>6.6</b>	<b>102.0%</b>
3	Үүнээс:	Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	292.6	248.3	254.9	6.7	102.7%
		ХАЦЭХ-ДҮТ	сая. кВтц	29.3	75.6	75.5	- 0.08	99.9%
		Импортын ЦЭХ	сая. кВтц	0.256	0.335	0.337	0.0	100.5%
4	Түгээх ДЭХ		мян.Гкал	325.7	344.0	348.8	4.8	101.4%
5	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	хувь	4.6%	6.6%	7.9%	1.3%	84.0%
		биет	сая. кВтц	14.83	21.38	25.97	4.59	82.3%
<b>Нийт орлого</b>			<b>сая.төг</b>	<b>76,693.7</b>	<b>83,778.8</b>	<b>85,955.4</b>	<b>2,176.6</b>	<b>102.6%</b>
6	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	75,715.4	76,750.0	75,118.8	- 1,631.20	97.9%
		Бусад орлого	сая.төг	978.3	978.3	4,461.3	3,483.03	456.0%
		50 мВт ТХН-ийн санхүүжилт	сая.төг	-	785.9	1,107.4	321.50	140.9%
		Татаас	сая.төг	-	5,264.6	5,267.9	3.300	100.1%
<b>Нийт зардал</b>			<b>сая.төг</b>	<b>78,829.2</b>	<b>91,601.4</b>	<b>87,711.4</b>	<b>- 3,890.1</b>	<b>104.4%</b>
7	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	75,515.8	74,998.5	70,362.4	- 4,636.1	106.6%
		ХАЦЭХ-ний зардал	сая.төг	2,601.1	15,229.7	15,140.5	- 89.2	100.6%
		Бусад зардал	сая.төг	712.3	712.3	1,501.3	789.0	47.4%
		50 мВт ТХН-ийн санхүүжилт	сая.төг	-	661.0	707.2	46.2	93.5%
8	Татвар төлөхийн өмнөх ашиг, / алдагдал/		сая.төг	(2,135.6)	(7,822.7)	(1,756.0)	6,066.7	445.5%
9	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал /		сая.төг	(2,135.6)	(7,822.7)	(1,892.4)	5,930.3	413.4%
10	БО-ын I төгрөгт ногдох зардал		төг	1,028	1,093	1,020	- 0.07	107.1%
<b>Нийт авлага</b>			<b>сая.төг</b>	<b>3,415.0</b>	<b>3,278.0</b>	<b>3,005.6</b>	<b>- 272.4</b>	<b>109.1%</b>
11	Үүнээс:	ЭХ-ний авлага	сая.төг	1,758.0	1,650.0	1,583.2	- 66.8	104.2%
		Бусад	сая.төг	1,657.0	1,628.0	1,422.4	- 205.6	114.5%
<b>Нийт өглөг</b>			<b>сая.төг</b>	<b>211,705.2</b>	<b>234,057.4</b>	<b>227,581.9</b>	<b>- 6,475.5</b>	<b>102.8%</b>
12	Үүнээс:	УХӨТ	сая.төг	204,370.2	207,562.2	202,050.0	- 5,512.2	102.7%
		БХӨТ	сая.төг	7,335.0	26,495.2	25,531.9	- 963.3	103.8%
13	Нийт ажилтан		тоо	620.0	737.0	674.0	- 63.0	109.3%
14	Нийт цалингийн сан		сая.төг	25,975	26,826	26,667	- 158.6	100.6%
15	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг	3,779.24	3,363.58	3,093.43	- 270.2	92.0%
16	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВтц	632.22	565.00	550.38	- 14.6	102.7%
		ДЭХ	кг/Гкал	192.56	191.40	191.08	- 0.3	100.2%

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь цахилгаан дулаан үйлдвэрлэж, түүнийгээ борлуулах үйл ажиллагаа явуулдаг Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага бөгөөд 66 хувийг Эрчим хүчний яам, 34 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар эзэмшиж байна.

Тусгай зөвшөөрлөөр олгосон үйл ажиллагааны хүрээнд удирдлагын оновчтой арга барилаар байгууллагын зан төлөв, соёлыг төлөвшүүлж, бүс нутгийн эрчим хүчний хэрэглээний өсөлтийг цаг ямагт дэмжин, найдвартай тасралтгүй явуулах эрхэм зорилготой ажиллаж байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль,

Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон эдгээрийг дагалдаж гарсан журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитын нэгж хэрэгжүүлж байна. Дотоод аудитын нэгжийн ажиллах журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан байна.

“ДБЭХС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор “Компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн тогтоох тухай” шийдвэр гарч, 23 нэгжид 747 албан хаагчийн орон тоотой байхаар баталсан байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны А/322 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Эрчим хүч, дулаан үйлдвэрлэсэн үйлдвэрлэлийн зардлыг хамсарсан зардлыг хуваарилах аргаар тооцож бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэнэ гэж заасан байгаа ч борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлэх” зөвлөх үйлчилгээний гэрээг “Грант торнтон аудит” ХХК-тай байгуулж, гэрээг дүгнэн, НБББББ-ийг гардан авсан боловч мөрдөж эхлээгүй байна.

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 123.6 тэрбум төгрөгөөр буюу 48.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	247,398.22	505,610.12	258,211.89
Авлага	3,043,731.89	3,005,579.24	(38,152.65)
Бараа материал	3,199,738.85	5,544,933.93	2,345,195.08
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	31,913.62	22,289.50	(9,624.12)
Бусад эргэлтийн хөрөнгө	216,819.00	126,867.50	(89,951.50)
Үндсэн хөрөнгө	227,366,318.03	348,518,986.85	121,152,668.82
Биет бус хөрөнгө	19,080,918.25	19,018,997.21	(61,921.04)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>253,186,837.86</b>	<b>376,743,264.34</b>	<b>123,556,426.48</b>
Өглөг	12,910,468.54	28,050,625.49	<b>15,140,156.95</b>
Урьдчилж орсон орлого	603,391.87	113,412.13	<b>(489,979.75)</b>
Урт хугацаат зээл	114,379,788.92	199,417,924.30	<b>85,038,135.38</b>
Хойшлогдсон орлого	42,308,425.69	68,698,699.28	<b>26,390,273.59</b>
Эздийн өмч	82,984,762.84	80,462,603.15	(2,522,159.70)
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>253,186,837.86</b>	<b>376,743,264.34</b>	<b>123,556,426.48</b>

Нөлөө бүхий өөрчлөлт орсон данс нь бараа материал болон үндсэн хөрөнгийн данс байна. Бараа материалын дансны үлдэгдэл 5,544.9 сая төгрөг болж 2,345.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны эцэст 138.5 мянган тонн нүүрс худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 348,519.0 сая төгрөг болж 121,152.7 сая төгрөгөөр өссөн байна. Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50МВт шинэ станцаар өргөтгөх ажилтай холбоотой хөгжлийн банкны зээл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 125,291.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн, өөрийн хөрөнгөөр 278.2 сая төгрөгийн компьютер, машин тоног төхөөрөмж худалдаж авсан, 1,187.1 сая төгрөгийн хөрөнгө акталсан зэрэгтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 28,050.6 сая төгрөг болж, 15,140.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өр төлбөр дансанд нөлөө бүхий өөрчлөлт орсон нь дансны өглөг бөгөөд 11,738.3 сая төгрөгөөр өссөн байна.

Татварын өр 4,367.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үүний 3,666.8 сая төгрөг нь НӨАТ-ын өр байна.

Урт хугацаат зээл дансны үлдэгдэл 199,417.9 сая төгрөг болж 85,038.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 90,919.4 сая төгрөгийн зээл нэмж авсан, тайлант онд 8,299.3 сая төгрөгийн урт хугацаат зээлийн төлөлт хийсэн, ханшийн зөрүүнд 2,417.9 сая төгрөг тооцсонтой холбоотой байна.

Хойшлогдсон орлого данс 68,698.7 сая төгрөг болж 26,390.3 сая төгрөгөөр өссөн нь Чойбалсан ДЦС-ын 50МВт өргөтгөх төслийн ажлын гүйцэтгэлд 26,584.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын элэгдлийн зардал болох 194.4 сая төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Эрчим хүчний сайдаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/17 дугаар тушаалаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт орлогыг 76,694.9 сая, нийт зардлыг 78,830.5 сая төгрөгөөр баталсан байна. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлыг 3,779.2 сая төгрөгөөр баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/301 дүгээр тушаалаар нийт орлогыг 7,085.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 83,778.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 12,772.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 91,601.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлыг 415.7 сая төгрөгөөр бууруулж 3,363.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 560.0 сая төгрөгийн турбины нөөц сэлбэг авах хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй, бусад тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд 139.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засварт 4.4 сая төгрөгийн ажил нэмж тодотгосонтой холбоотой байна.

Гүйцэтгэлээр 85,955.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 87,711.4 сая төгрөгийн зардал гарган, 1,756.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын төлөвлөгөө 2,176.6 сая төгрөгөөр давсан бөгөөд үүнд үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус ашиг гол нөлөө үзүүлсэн байна.

Зардлын төлөвлөгөө 3,890.1 сая төгрөгөөр буурсан бөгөөд үүнд урт хугацаат зээлийн хүүгийн зардал буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

### **3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

“ДБЭХС” ТӨХК-ний гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/02 дугаар тушаалаар 2024 онд худалдан авах бараа ажил, үйлчилгээний төсөвт өртгийг 9,014.3 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант онд батлагдсан төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн бөгөөд хамгийн сүүлд 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр А/118 дугаар тушаалаар 9,410.8 сая төгрөгийн 96 ажил батлагдсан байна.

Гүйцэтгэлээр аюулгүйн нөөц, харуулын цэгүүдэд шаардлагатай тусгай хэрэгсэл зэрэг 7 ажил эх үүсвэрийн дутагдалтай байдлаас шалтгаалан хийгдээгүй бөгөөд бусад 89 ажил 100 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Оюунхэрлэн, Б.Одхүү нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК 2024 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ний 02/118 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Материаллаг байдлыг 2024 оны нийт орлогын 85,955.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 859.5 сая төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг мэдээлээгүй байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог" гэж тодорхойлсон ба тус байгууллагын захиргаа, үйлдвэрчний эвлэл хооронд байгуулсан хамтын гэрээнд Эрчим хүчний салбарын болон бусад салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан ажилтан болон ахмад ажилчдад сар бүр 15,000.0 төгрөг олгож байгаа нь бусад хууль тогтоомжид заагдаагүй, суурь хэм хэмжээнд үндэслээгүй байна.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор “ДБЭХС” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд төрийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн хүн томилсон нь Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 3.1-д “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан болзлоос гадна дараах нийтлэг шаардлагыг хангасан байна” 3.1.7."төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитыг эхний хагас жилийн анхан шатны баримтад хийж, илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн тайланд тусгасан болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар нийт 4,313.1 сая төгрөгийн 31 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 20.5 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 1,466.4 сая төгрөгийн 7 албан шаардлага, 1

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

хариуцлага тооцуулах албан шаардлага, 2,288.1 сая төгрөгийн 9 зөвлөмж өгч хэрэгжилтийг 100 хувь хангуулан, худалдан авах ажиллагаатай холбоотой 538.1 сая төгрөгийн ашиг сонирхлын зөрчилтэй болон гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрснийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	7	20.5	7	20.5	100
Албан шаардлага	7	1,466.4	7	1,466.4	100
Хариуцлага тооцуулах	1	0.0	1	0.0	100
Зөвлөмж	9	2,288.1	9	2,288.1	100
Хууль хяналтын байгууллагад	1	538.1	1	538.1	100
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>4,313.1</b>	<b>7</b>	<b>4,313.1</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар "Түлхүүр гардуулах нөхцөлтэй Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөх" төслийн ажлын бүртгэлийг тайланд хэрхэн тусгасан талаар үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 603.4 сая төгрөгийн 9 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 26.1 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 226.1 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 351.2 сая төгрөгийн 4 алдаа, зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Б/501 дүгээр тушаалаар Төслийн зохицуулагчийг томилон цалинг 5.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Гэтэл төслийн ажилтанд компанийн ажилтантай адилтган үр дүнгийн нэмэгдэлд 4.3 сая төгрөг, удаан жилийн нэмэгдэлд 5.0 сая төгрөг, ур чадварт 2.5 сая төгрөгийг тус тус компанийн цалингийн зардлаас олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.6 дахь "сахилга баттай байх", 4.1.3 дэх "үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-ыг хориглоно, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна
2. Гүйцэтгэх захирлын 2024 оны А/243 дугаар тушаалаар байгуулагдсан компанийн нийт зэрэгтэй ажилтнуудын дунд зохион байгуулсан "Аттестатчилал 2024" шалгалтын комиссын 9 гишүүнд үндсэн цалингийн 40%, ажилтнуудаа шалгалтад амжилттай бэлтгэсэн цехийн дарга, инженер техникийн 12 ажилтанд үндсэн цалингийн 20% урамшууллыг хамтын гэрээг үндэслэн олгосон багш шавийн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-ыг хориглоно, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

## 5.2 Албан шаардлага

3. Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн харуул хамгаалалтын 4 албан хаагчид ажлаас халагдсаны тэтгэмжийг олговол зохих цалингийн дунджаар бодож, 129.8 сая төгрөгөөр илүү олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-т "Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно", 82.1.3-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын **үндсэн цалинтай тэнцэх**", 82.1.4-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан бол дөрөв ба түүнээс дээш сарын **үндсэн цалинтай тэнцэх**", Хамтын гэрээний 5.15-т "Компанийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байрыг цөөрүүлэх, орон тоог цомхотгох, хувьчлагдсан тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор тус байгууллагад 1-4 жил ажилласан бол 4 сар, 5-10 жил ажилласан бол 6 сар, 11-15 жил ажилласан бол 12 сар, 16 ба түүнээс дээш жил ажилласан бол **24 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг** сүүлийн нэг жилийн дундаж цалингаар бодож **олгоно**" гэж заасныг зөрчсөн байна.
4. Хамтын гэрээг үндэслэн гүйцэтгэх захирлын 2024 оны Б/113, Б/282, Б/464, Б/510 дугаар тушаалаар эрчим хүчний тэргүүний ажилтан цол, тэмдгийн урамшуулал ахмадуудад 33.6 сая төгрөг, ажилтан нарт 19.6 сая төгрөгийг тус тус олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог" гэж тодорхойлсон байна. Дээрх урамшууллуудыг олгох эрх зүйн суурь хэм хэмжээ байхгүй байна. Хамтын гэрээг Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлж, өөрчлөлт оруулах.
5. Гүйцэтгэх захирлын 2024 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан ашиглагч талаас төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран ажиллах, хяналт тавих ажлын хэсгийн 14 ажилтанд үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний 43.1 сая төгрөгийн нэмэгдэл хөлсийг 2024 оны 3, 4, 5, 6 дугаар саруудад олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-ыг хориглоно, гэж заасныг зөрчсөн байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт 1: Тайлант онд "Найнги" ХХК-д 87.7 сая төгрөгийн алданги төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсныг тайлан, тодруулгад тусгаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж 1: Өр төлбөрийг бүртгэлд тусгаж, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх.

Илрүүлэлт 2: “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлэх” зөвлөх үйлчилгээний гэрээг “Грант торнтон аудит” ХХК-тай байгуулж, гэрээг дүгнэн, НБББББ-ийг гардан авсан боловч мөрдөж эхлээгүй, хөрөнгөөр бүртгээгүй.

Өгсөн зөвлөмж 2: НБББББ-ийг ТУЗ-өөр хэлэлцүүлэн, батлуулж, хөрөнгөөр бүртгэн, мөрдөж ажиллах.

#### 2. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт: Жилийн эцсийн тооллогын ажлын тайланд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд тооллогоор илэрсэн биетээр байхгүй 5 нэр төрлийн 52 ширхэг 146.2 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэлгүй хөрөнгийн бүртгэл, тайланд байгаагаар тусгасан.

Өгсөн зөвлөмж: Уг хөрөнгүүдэд дахин хяналт хийж шийдвэрлэх.

#### 3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор ТУЗ-д хүргүүлэх зөвлөмж

Илрүүлэлт: Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд төрийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн иргэнийг томилсон нь Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 3.1.7 дахь "төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх" гэсэн шаардлагыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу ТУЗ-ын гишүүнийг томилох.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. гэж заасны дагуу ирүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төслийн зохицуулагчид үндсэн ажилтны адил нэмэгдэл олгосон.	1	11,872.73	1	11,872.73								
"Аттестатчилал 2024" шалгалтын комиссын гишүүдэд урамшуулал давхардуулал олгосон.	1	14,173.08	1	14,173.08								
Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид ажлаас халагдсаны тэтгэмжийг илүү олгосон.	1	129,770.16			1	129,770.16						
Эрхзүйн суурь хэм хэмжээгүй урамшууллыг хамтын гэрээнд тусгаж олгосон.	1	53,205.00			1	53,205.00						
Төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран ажиллах, хяналт тавих ажлын хэсгийн 14 ажилтанд үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгосон.	1	43,112.30			1	43,112.30						
Шүүхийн шийдвэрээр төлөхөөр болсон алдангийг тайлан, тодруулгад тусгаагүй.	1	87,695.64					1	87,695.64				
НБББББ-ийг хөрөнгөд бүртгээгүй, мөрдөж эхлээгүй.	1	117,275.40					1	117,275.40				
Ж илийн эцсийн тооллогоор илэрсэн биетээр байхгүй хөрөнгийг шийдвэрлээгүй.	1	146,258.65					1	146,258.65				
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд төрийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн иргэнийг томилсон.	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>603,362.96</b>	<b>2</b>	<b>26,045.81</b>	<b>3</b>	<b>226,087.46</b>	<b>4</b>	<b>351,229.69</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 01/СБ 01760205

Чойбалсан хот

00А-2025/005/НА-САН-ТӨВГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Б/501 дүгээр тушаалаар Төслийн зохицуулагчийг томилон цалинг 5.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Гэтэл төслийн ажилтанд компанийн ажилтантай адилтган үр дүнгийн нэмэгдэлд 4.3 сая төгрөг, удаан жилийн нэмэгдэлд 5.0 сая төгрөг, үр чадварт 2.5 сая төгрөгийг тус тус компанийн цалингийн зардлаас нийт 11.9 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.6 дахь “сахилга баттай байх”, 4.1.3 дэх “үр ашигтай байх”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”-ыг хориглоно, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 11,872,727.27 /Арван нэгэн сая найман зуун далан хоёр мянга долоон зуун хорин долоон төгрөг хорин долоон/ мөнгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Энхбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Д.НАРМАНДАХ

2117144066  
ХТҮХЗЛТ 3370001

2125050134



ТӨР ИЙН АУДИТЫН АГТ ТӨЛБӨР ДОН

ДОРНОД ХАЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АХЛАХ АУДИТОР АКТ ДАГАВЬ ГИДАХ

2025 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 08/59 АМБДЗ05

Чойбалсан хот

00А-2025/005/НА СГА-ТӨИГ

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/243 дугаар тушаалаар байгуулагдсан компанийн нийт зэрэгтэй ажилтнуудын дунд зохион байгуулсан “Атгестатчилал 2024” шалгалтын комиссын 9 гишүүнд үндсэн цалингийн 40%, ажилтнуудаа шалгалтад амжилттай бэлтгэсэн цехийн дарга, инженер техникийн 12 ажилтанд үндсэн цалингийн 20% урамшуулал олгосон байна. Энэ нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн ажлыг хийснээр цалин, нэмэгдлийг авч байхад урамшууллыг давхардуулан олгосон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3 дэх “үр ашигтай байх”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”-ыг хориглоно, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-т “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон урамшууллын 14,173,082.40 /Арван дөрвөн сая нэг зуун далан гурван мянга наян хоёр төгрөг дөчин/ мөнгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Энхбаатар нарт хариуцуулав.

2125050136

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР




И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР



Д.НАРМАНДАХ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 01/187 А/116 0305

Чойбалсан хот

2025-2025/005/НА-СГА-ТӨГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн харуул хамгаалалтын 4 албан хаагчид ажлаас халагдсаны тэтгэмжийг хамтын гэрээг үндэслэн 129.8 сая төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-т “Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно”, 82.1.3-т “тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын **үндсэн цалинтай тэнцэх**”, 82.1.4-т “тухайн аж ахуйн нэгж, байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан бол дөрөв ба түүнээс дээш сарын **үндсэн цалинтай тэнцэх**”, Хамтын гэрээний 5.15-т “Компанийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байрыг цөөрүүлэх, орон тоог цомхотгох, хувьчлагдсан тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор тус байгууллагад 1-4 жил ажилласан бол 4 сар, 5-10 жил ажилласан бол 6 сар, 11-15 жил ажилласан бол 12 сар, 16 ба түүнээс дээш жил ажилласан бол 24 сарын **албан тушаалын цалинтай тэнцэх** хэмжээний тэтгэмжийг сүүлийн нэг жилийн дундаж цалингаар бодож олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээрийн 5.17 “... 24 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг бодож олгоно” гэж заасан байхад Тус компанийн Хамтын гэрээний 5.15-д “... 24 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг сүүлийн нэг жилийн дундаж цалингаар бодож олгоно” гэж заасан нь хамтын хэлэлцээрээр ажилтан олгохоор тогтоосон тэтгэмжийг дордуулж гэрээнд тусгасан эсвэл хамтын гэрээний 5.15 дэх заалт утга найруулгын алдаатай хүчин төгөлдөр бус байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”. Үүнд: 4.2.1.11-л “хууль тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан

2125040545

зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хамтын гэрээг хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулах, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Энхбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР



Д.НАРМАНДАХ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 02/133 А/1160505

Чойбалсан хот

2024-2025/005/НА-СТА-ТӨВТ

Зөрчил арилгах тухай

6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хамтын гэрээг үндэслэн гүйцэтгэх захирлын 2024 оны Б/113, Б/282, Б/464, Б/510 дугаар тушаалаар эрчим хүчний тэргүүний цол, тэмдгийн урамшуулал ахмадуудад 33.6 сая төгрөг, ажилтан нарт 19.6 сая төгрөгийг тус тус олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”-ыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “хамтын гэрээ” гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог” гэж тодорхойлсон байна. Дээрх урамшууллуудыг олгох эрх зүйн суурь хэм хэмжээ байхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”. Үүнд: 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрчим хүчний тэргүүний цол, тэмдгийн урамшууллын дагалдах мөнгийг хууль, тогтоомжид нийцүүлэн олгох, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх

2125040546

захирал Ө.Жаргалсайхан, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Энхбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



И СЭМЖИДМАА  
Д.НАРМАНДАХ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 03/189 А/1160305

Чойбалсан хот

2024-2025/005/НА-СТА-ТӨИТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/65 дугаар тушаалаар байгуулагдсан ашиглагч талаас төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран ажиллах, хяналт тавих ажлын хэсгийн 14 ажилтанд үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний 43.1 сая төгрөгийн нэмэгдэл хөлсийг 2024 оны 3-6 дугаар саруудад олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”-ыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”. Үүнд: 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын хэсгийн комисст цалингийн нэмэгдэл хувь олгодог байдлыг зогсоох, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөр орсон нэмэлт өөрчлөлтийг баримтлан ажиллах, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Энхбаатар нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ



2125040549